

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд хийсэн тайлан

АУДИТЫН КОД: БУА-2021/03/ШТА-ГА

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын
хэрэгжилт хангалтгүй, үр нөлөө бага байна.

БУЛГАН АЙМАГ 2021 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
Аудитор Б.Энхтөр
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон

үгийн

тайлбар.....4

Хүснэгтийн

товъёг.....5

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх

мэдэгдэл.....6-7

БҮЛЭГ А. Хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах түгээх тогтолцоо бүрдсэн байна.....8

А.1 Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, хангалт, үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хэрэгжилтийн зарим асуудлууд хангалтгүй байна.....8

А.1.1 Монгол Улсад бүртгэлтэй эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж байгаа ч төрийн болон ТББ-уудтай хамтран ажиллах гэрээг бүрэн байгуулж ажиллаагүй байна.....8

А.1.2 Хүн ам, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагыг эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах зорилго тавин ажиллаж байгаа ч ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн хамгаалалт, хадгалалт, хүний нөөц дутмаг байна.....8-9

А.1.3 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сангууд нь Монгол улсад бүртгэлтэй эм, эмнэлгийн хэрэгслээр ханган нийлүүлж байгаа ч шинээр үүсгэн байгуулагдаж байгаа эмийн сангийн байршил хоорондын зай ойрхон нэг дор төвлөрсөн байна.....9-10

А.1.4 Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлж, үр дүнтэй зохион байгуулсан уу? Хамааралгүй болно.....10

А.2 Эмийн санхүүжилт үр ашигтай байна.....10

А.2.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас 2018-2020 онуудад нийт 14093.6 сая төгрөгийн санхүүжилт авсан нь төрөөс дэмжлэг үзүүлсэн гэж үзжээ.....10-11

А.2.2 Санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах өндөр өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас 2018-2020 онуудад санхүүжилт аваагүй. Энэ нь өндөр өртөгт эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээ байгуулаагүйтэй холбоотой байна.....11

А.2.3 Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийн зардал санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж буй дэмжлэг туслалцаа нь хүн амыг зорилтот бүлгээр нь ангилж олгогдоогүй, ЭМ-ийн даатгалаа бүрэн төлсөн иргэд дэмжлэг тусламжид хамрагддаг байна.....11

А.3 ЭМТ болон эмийн сангуудын үйл ажиллагаанд тавих хяналтын үйл ажиллагаа бүрэн хийгдээгүй, төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.....11

А.3.1 Эмийн зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа бодлого, чиглэл харилцан уялдаатай, нэгдсэн зохицуулалтайгаар боловсруулагдсан байна.....11-12

А.3.2 Эмийн сангуудын үйл ажиллагааг тогтворжуулах зорилгын хүрээнд 1995 онд ЭМЯ, НҮБ-ийн хүүхдийн сан хамтарсан “Эрүүл мэнд хамт олон төсөл”-өөр нэг суманд дунджаар 2.5-5.0 сая төгрөгийн санхүүжилтийн тусламж үзүүлснээс хойш төрөөс дэмжлэг туслалцаа үзүүлээгүй гэсэн тайлбарыг өгч байгаа нь төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт алдагдахад хүрч байна.....12

А.3.3 Эмийн зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллажээ.....	12-13
А.3.4 Эм зүйн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа боловч сүүлийн жилүүдэд сургалт явагдаагүй нь төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэгдэж байна.....	13
Б.Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжүүлснээр хүн амын өвчлөл буурсан ч эмийн зохистой хэрэглээ бүрэн төлөвшөөгүй байна.....	13
Б.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэх ажил хийгдээгүй байна.....	13
Б.1.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүйгээс аймгийн хэмжээнд төлөвлөгөө боловсруулж батлаагүй.....	13-14
Б.1.2 Эрх зүйн орчин бүрдсэн ч хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит үнэлээгүй байна.....	14-15
Б.1.3 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу ЭМЯ-ны асуудал тул орон нутагт хамааралгүй асуудал болно.....	15
Б.2 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт сурталчилгаа, заавар зөвлөмжийг өгч ажилласан байна.....	15
Б.2.1 Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016 стандартыг шинэчлэн боловсруулах шаардлага үүссэн байна.....	15
Б.2.2 Эм зүйн ба эмнэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлэх, нөхцөл бүрдсэн ч иргэдэд эмийн зохистой хэрэглэх дадал төлөвшсөн эсэхийг тодорхойлж, мэдээллээр бүрэн хангагдсан эсэхэд хийсэн судалгаа, үнэнлт өгсөн ажил хангалтгүй байна.....	16
Б.2.3 Орон нутагт мэргэжилтэн бэлтгэх сургалт, сургууль байхгүй тул хамааралгүй болно.....	16
Б.2.4 Эмийн зохистой хэрэглээний талаар хийсэн сургалт, сурталчилгааны давтамж тодорхой бус, үр дүнг тооцож, үнэлээгүй байна.....	16-17
ДҮГНЭЛТ.....	17-18
ЗӨВЛӨМЖ.....	18-19
МЭДЭГДЭЛ.....	19

Товчилсон үгийн тайлбар

ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргынтамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
УИХ	Улсын Их хурал
ЭМ	Эрүүл мэнд
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ЭМТ-үүдийн багц үйлчилгээ үзүүлж ЭМД-ын хэлтсээс авсан санхүүжилтийн дүн, иргэдийн тоо	11
Хүснэгт 2	Эмийн зохистой хэрэглээ, чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний 2018-2020 оны сургалт, сурталчилгаа	16-17

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	ЭМТ-үүдийн эмийн хадгалалт, хамгаалалтын өрөөний байдал	9
Зураг 2	Санхүүжилтийн дүн, хамрагдсан иргэдийн тоо	10

Дүрслэл

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Санхүүжилтийн дүн, хамрагдсан иргэдийн тоо	10



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/20

Булган

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу "Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Аймгийн засаг дарга, Эрүүл мэндийн даатгалын хэтсийн дарга, Эрүүл мэндийн газрын дарга, нарт хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Б.Ариун-Эрдэнэ/, Эрүүл мэндийн газрын дарга /С.Нарантуяа/, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Чулуунчимэг/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, биелэлтийг тооцон хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ж.Энхцоодол/-т даалгасугай.

5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, Төрийн аудитын байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд түгээхийг ахлах аудитор /П.Мөнхтуяа/-т үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР



D: /bnchig hereg/2021/tushaal/TAtushaal.doc

006010075

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөнд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган Улсын Их болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд: - Хүн амын эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрдсэн эсэх. - Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр хүн амын өвчлөлт буурч эмийн зохистой хэрэглээ төлөвшсөн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Төрөөс эмийн талаар баримтлах бодлого эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын талаарх төрийн зохицуулалт, “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан тайлан, хяналт-үнэлгээний тайлан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмжүүд, түүний хэрэгжилтийн тайлан, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн болон өвчин эмийн жагсаалтыг баталсан шийдвэр, үндэслэл дээрх жагсаалтад орсон эмийн үнийн дээд хязгаарыг баталсан шийдвэр болон бусад холбогдох баримт материалыг хамрууллаа. Эрүүл мэндийн яам, Хүний эмийн зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Татварын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, орон нутгийн засаг, захиргааны нэгж болон бусад холбогдох байгууллагын 2018-2020 оны аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ /INTOSAI/-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020, “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020, “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

стандартад заасан зарчим, арга зүй, Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээг хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор П.Мөнхтуяа, аудитор А.Сувдаа, Э.Одбаясах нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудитын явцын тайланг 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хүргүүлж ажиллалаа.

Хүндрэл бэрхшээл

Аудит хийх ажлын хоног хугацаа богино, 2 гүйцэтгэлийн аудит зэрэг хийгдэж байгаа нь ажлын ачаалал их, гүйцэтгэлийн аудит чанаргүй хийгдэх эрсдэл үүсэж байна.

А. Хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах түгээх тогтолцоо бүрдсэн байна.

А.1. Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, хангалт, үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хэрэгжилтийн зарим асуудлууд хангалтгүй байна.

А.1.1. Монгол Улсад бүртгэлтэй эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж байгаа ч төрийн болон ТББ-уудтай хамтран ажиллах гэрээг бүрэн байгуулж ажиллаагүй байна.

Аймгийн хэмжээнд 2 эм хангамж, нэгдсэн эмнэлгийн эмийн сан 1, 34 эмийн сан нийт 37 эмийн сан үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр эмийн сангууд нь Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.2.¹, Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын 3.1.1.² гэсэн заалтуудыг баримтлан Монгол улсад бүртгэлтэй эм, эмнэлгийн хэрэгслээр ханган түгээж байна.

Аймгийн ЭМГ нь 2020 онд эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулж тендерт шалгарсан 17 компани, ерөнхий гэрээний 7 нийт 24 байгууллагатай гэрээ хийж эм эмнэлгийн хэрэгслийг нийлүүлж, мөн эмийн сан, ЭМТ-үүдтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа ч түүвэрлэлтээр 8 эмийн сангийн гэрээ хийсэн байдлыг дүгнэхэд зарим эмийн сан нь сум орон нутгийн болоод Булган аймгийн “Эм холбоо” ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллаагүй нь Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын 4.1.5.³ гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс эмийн зохистой хэрэглээ төлөвших, эмийн талаар баримтлах бодлого, чиглэл, мэдээлэл бүрэн хангагдахгүй байна.

Цаашид төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн хүрээнд ЭМГ болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг байгуулж, жил бүр гэрээг дүгнэж ажиллах шаардлагатай байна.

А.1.2. Хүн ам, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагыг эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах зорилго тавин ажиллаж байгаа ч ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн хамгаалалт, хадгалалт, хүний нөөц дутмаг байна.

Төрөөс баримтлах бодлогын хүрээнд аймгийн дэд хөтөлбөрт тусгагдсаны дагуу Нийгмийн бодлогын хэлтэс, ЭМГ нь жил бүр эрүүл мэндийн бодлогын хүрээнд хийгдэх ажлыг тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж байгаа ч сумдын ЭМТ-үүд эм, эмнэлгийн хэрэгслийн хамгаалалт, хадгалалтын өрөө, тасалгаа, хүний нөөц дутмаг байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сангийн хүний нөөцийн судалгаа авахад нийт 36 эмийн санчаас 14 эм зүйч, 12 эм найруулагчийн мэргэжилтэй байна.

Энэ нь эмийн санд тавигдах шаардлага MNS 5260:2015 стандартын 5.2.⁴, 5.3.⁵ гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, түүвэрлэлтээр 4 сумдын 5 эмийн сангийн үйл ажиллагаатай танилцахад эм зүйч мэргэжилтэй 1, эм найруулагч 4 хүн эмийн сангийн үйл ажиллагааг эрхэлж байна.

Түүвэрлэлтэд хамрагдсан Орхон, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг сумдын ЭМТ-үүдийн эм баригч болон эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, хамгаалалтыг шалгахад суманд эм баригч дутмаг, эм, эмнэлгийн хэрэгслийг стандартын өрөө тасалгаанд хадгалдаггүй, сумын эмийн сангийн нөөцийн өрөөнд, зарим нь өөрийн эмнэлгийн болон өөр байгууллагын хажуу өрөөнд хадгалж байгаа нь эм, эмнэлгийн

¹ Эмийн үндэсний бодлого нь эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амыг өндөр идэвхтэй, чанарын баталгаатай, эмийн бүртгэлд бүртгэгдсэн эмээр тасралтгүй, хүртээмжтэй, жигд хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэнэ

² эмийн бүртгэл, чанарын хяналт, эм үйлдвэрлэлийн зохистой дадлыг бэхжүүлж, хэрэглэгчийг эмчилгээний идэвхтэй, чанартай, аюулгүй эмээр хангах

³ “бодлогыг хэрэгжүүлэхэд сонирхогч бүх талууд, олон улсын байгууллага, төрийн байгууллагын оролцоог ханган хамтран ажиллах

⁴ Нийтийн үйлчилгээтэй, эмийн сангийн үйл ажиллагааг мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан эм зүйч гардан удирдаж, эрхлэгчийн үүргийг гүйцэтгэнэ”,

⁵ Аймгийн төвийн эмийн сангийн эрхлэгч нь тухайн орон нутагт оршин сууж, тухайн эмийн санг мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

хэрэгслийн тухай хуулийн 11.2.2.⁶, 11.3.⁷, Эмийн санд тавигдах шаардлага MNS 5260:2015 стандартын 8.1.8.⁸ гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, шаардлага хангахгүй өрөөнд эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалж байна.

Үүнийг зургаар харуулбал:

ЭМТ-үүдийн эм, эмнэлгийн хэрэгсэл хадгалалт, хамгаалалтын байдал



Сумдын ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалж ашиглаж байгаа өрөө, тасалгаа, өнөөгийн байдал нь стандартын дагуу хадгалж ашигладаггүй, МХГ-аас сүүлийн 3 жил эм, био бэлдмэлийн хяналтын улсын байцаагчийн орон тоо сул байсан тул хяналт шалгалт хийгдээгүй гэсэн тайлбар ирүүлсэн нь эм эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, эм тарианы чанар алдагдах магадлалтай байна.

Иймд сумдын ЭМТ-ийн эм эмнэлгийн хэрэгслийг хадгалах, хамгаалах стандартын нөөцийн өрөө тасалгаатай болгох ажлыг зохион байгуулахыг ЭМГ-т албан шаардлага хүргүүлэх, эм, био бэлдмэлийн хяналтын улсын байцаагчийг авч ажиллуулах зөвлөмжийг тус тус хүргүүлж байна.

А.1.3. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сангууд нь Монгол улсад бүртгэлтэй эм, эмнэлгийн хэрэгслээр ханган нийлүүлж байгаа ч шинээр үүсгэн байгуулагдаж байгаа эмийн сангийн байршил хоорондын зай ойрхон нэг дороо төвлөрсөн байна.

Аймгийн хэмжээнд эм үйлдвэрлэх болон эм найруулах үйл ажиллагаа явуулдаг эмийн сан байхгүй, төрөөс баримтлах бодлогын хүрээнд хүн амд эм зүйн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх зорилгоор шинээр эм хангамж болон эмийн сангийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 2018 онд 5, 2019 онд 8, 2020 онд 1 нийт 14 эмийн санд олгожээ.

Шинээр эмийн сан үүсгэн байгуулагдаж байгаа ч аймаг сумдын ЗДТГ, Булган аймаг дахь "Эм холбоо" ТББ болон бусад холбогдох байгууллагууд хоорондоо уялдаагүй, хамтарч ажилладаггүйгээс шалтгаалан эмийн сангуудын хоорондын зай, байршлыг нь оновчтой тогтоож өгөөгүй, нэг дор төвлөрсөн, аймаг, сумын эмийн

⁶ "Эмийн хадгалалт, хамгаалалтын журам зөрчих

⁷ "Зориулалтын бус газар эм, эмнэлгийн хэрэгсэл хадгалах, худалдахыг хориглоно

⁸ "Эм эмнэлгийн хэрэгсэл, туслах материал, түүхий эдийг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлд хадгалах нөхцөл бүрдүүлсэн нөөцийн өрөөтэй байна

сангийн хоорондын зай 100-500 метрийн хооронд байгаа нь Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 16.1.⁹ гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Цаашид эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.2.¹⁰, Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын 3.1.1.¹¹ гэсэн заалтууд болон бодлогын хүрээнд эмийн сангуудын хоорондын зай, байршлыг оновчтой тогтоож өгснөөр иргэдэд илүү хүртээмжтэй, түргэн тусламж авах цаг хугацааг хэмнэх боломжийг нээж өгнө.

А.1.4. Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлж, үр дүнтэй зохион байгуулсан уу?


Хамааралгүй болно.

А.2 Эмийн санхүүжилт үр ашигтай байна.

А.2.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас 2018-2020 онуудад нийт 14093.6 сая төгрөгийн санхүүжилт авсан нь төрөөс дэмжлэг үзүүлсэн гэж үзжээ.

Аймгийн ЭМД-ын сангаас төрийн болон хувийн эмнэлгүүд, ЭМТ-үүд, рашаан сувилал, эмийн сангуудад хөтөлбөр төслийн, ор хоногийн, хөнгөлөлттэй эмийн, бусад эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэхэмжлэлийн дагуу анхан шатны баримтад тулгуурлан санхүүжилтийг хянаж 2018-2020 онуудад нийт 14093.6 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Санхүүжилтийн дүн, хамрагдсан иргэдийн тоог графикаар харуулбал:



Графикаас харахад төрөөс үзүүлж байгаа эрүүл мэндийн дэмжлэг, тусламж үйлчилгээнд хамрагдсан 2018-2020 он хүртэлх иргэдийн тоог харьцуулахад 4 дахин нэмэгдсэн нь хөнгөлөлттэй эмийг хязгаарлаж өгөхөө больсон, өрхийн эмнэлэг болон ЭМТ-үүдэд үзүүлж байгаа 4 багц тусламж үйлчилгээ нэмэгдсэн, өвчлөл ихэссэн мөн иргэд эрүүл мэнддээ анхаарал хандуулж байгаа хандлага, сургалт, сурталчилгаа зэрэгтэй холбон үзэж байна.

ЭМ-ийн байгууллагуудаар үзүүлж байгаа тусламж үйлчилгээг түүвэрлэн үзэхэд аймгийн төвийн өрхийн эмнэлэг, сумдын ЭМТ-үүд сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо шинжилгээ гэсэн багц үйлчилгээг харилцан адилгүй үйлчилж төрөөс үзүүлж байгаа дэмжлэгийг бүрэн хэмжээнд хамрагдаж аваагүй байна.

ЭМТ-үүдийн багц үйлчилгээ үзүүлж ЭМД-ын хэлтсээс авсан санхүүжилтийн дүн, иргэдийн тоог харьцуулсныг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт1/		/мян.төг/					
№	Байгууллагын нэрс	2018 он		2019 он		2020 он	
		Иргэний тоо	Санхүүжилтийн дүн	Иргэний тоо	Санхүүжилтийн дүн	Иргэний тоо	Санхүүжилтийн дүн
1	Баян-Агт сумын ЭМТ	162	1246.5	655	12949.7	1120	28256
2	Баяннуур сумын ЭМТ	67	749.0	741	13913.3	874	25773.1

⁹ Эмийн сангийн байршил болон үйлчлэх хүрээг тухайн орон нутгийн онцлогт тохируулан тогтоох, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах үйл ажиллагааг зохицуулах үүргийг нутгийн захиргааны байгууллага хүлээнэ.

¹⁰ Эмийн үндэсний бодлого нь эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амыг өндөр идэвхтэй, чанарын баталгаатай, эмийн бүртгэлд бүртгэгдсэн эмээр тасралтгүй, хүртээмжтэй, жигд хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэнэ.

¹¹ эмийн бүртгэл, чанарын хяналт, эм үйлдвэрлэлийн зохистой дадлыг бэхжүүлж, хэрэглэгчийг эмчилгээний идэвхтэй, чанартай, аюулгүй эмээр хангах

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө

3	Бугат сумын ЭМТ	0	0	311	6930.3	462	16947.8
4	Бүрэгхангай сумын ЭМТ	43	1290.0	358	5225.8	780	22236
5	Гурванбулаг сумын ЭМТ	0	0	235	4367.3	1080	25232.3
6	Дашинчилэн сумын ЭМТ	0	0	151	1513.9	1354	24824.1
7	Могод сумын ЭМТ	0	0	95	2895.3	905	18463.7
8	Орхон сумын ЭМТ	0	0	69	2149.9	616	20014.8
9	Рашаант сумын ЭМТ	10	300.0	555	6661.5	948	19120.5
10	Сайхан сумын ЭМТ	0	0	430	4172.9	1024	31756.5
11	Сэлэнгэ сум ЭМТ	297	5627.1	971	15675.4	1020	31658.5
12	Тэшиг сумын ЭМТ	0	0	293	3935.6	656	18865
13	Хангал сумын ЭМТ	0	0	158	3047.9	291	9753.4
14	Хялганат тосгон ЭМТ	441	6307.0	1375	15010.6	1984	32657.6
15	Цоожэд ӨЭМТ	106	1595.0	331	5395	118	1388.9
16	Эмийн цэцэглэн ӨЭМТ	0	0	34	1080.0	87	4603.4
Нийт дүн		1126	17114.6	6762	104924.4	13319	331551.6

Хүснэгтээс харахад 2018 онд 7 сумын ЭМТ 4 багц үйлчилгээг үзүүлж байсан, 2019, 2020 онд сумдын бүх ЭМТ эрүүл мэндийн тусламж үзүүлж байгаа ч харилцан адилгүй, жилд хамрагдсан иргэдийн тоо, авсан санхүүжилтийн дүнгээс үзэхэд зарим сумдын ЭМТ болон өрхийн эмнэлгүүд эрүүл мэндийн багц үйлчилгээг жигд хүртээмжтэй явуулаагүй нь ажиглагдаж байна.

Иймд эрүүл мэндийн 4 багц үйлчилгээ үзүүлж байгаа өрхийн эмнэлэг, ЭМТ-үүдийн үйлчилгээг жигд хүртээмжтэй, иргэдийг бүрэн хамруулж ажиллах шаардлагатай байна.

А.2.2. Санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах өндөр өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас 2018-2020 онуудад санхүүжилт аваагүй. Энэ нь өндөр өртөгт эм эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээ байгуулаагүйтэй холбоотой байна.

А.2.3. Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийн зардал санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж буй дэмжлэг туслалцаа нь хүн амыг зорилтот бүлгээр нь ангилж олгогдоогүй, ЭМ-ийн даатгалаа бүрэн төлсөн иргэд дэмжлэг тусламжид хамрагддаг байна.

Төрөөс үзүүлж буй дэмжлэг нь эмийн хөнгөлөлт, ор хоног, рашаан сувилал, бусад төсөл хөтөлбөрөөр үзүүлж буй санхүүжилтийн үзүүлэлтийг эмнэлэг, ЭМТ, эм хангамж, эмийн сангууд, рашаан сувиллын газруудын нэхэмжлэлийн дүнг анхан шатны баримтад хяналт хийн олгож байгаа ч онцолж ядуу эмзэг бүлгийн хүн амд зориулсан санхүүжилт авдаггүй, ЭМ-ийн даатгалаа бүрэн төлсөн иргэд бүрэн хамрагддаг байна.

А.3. ЭМТ болон эмийн сангуудын үйл ажиллагаанд тавих хяналтын үйл ажиллагаа бүрэн хийгдээгүй, төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.

А.3.1 Эмийн зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа бодлого, чиглэл харилцан уялдаатай, нэгдсэн зохицуулалттайгаар боловсруулагдсан байна.

Аймгийн ЗДТГ болон ЭМГ нь УИХ-ын 2016 оны 45 дугаар “МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоолоор баталсан Эрүүл мэндийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх 22 арга хэмжээний дагуу он, ондоо үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Үүнд: Аймгийн ЗДТГ нь эрүүл мэндийн салбарын бодлого, төлөвлөлтийн хүрээнд эрүүл мэнд хөтөч хөтөлбөрийг эрчимжүүлэх, эх хүүхдэд ээлтэй орчин

бүрдүүлэх, халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах гэсэн чиглэлүүдээр ажлыг зохион байгуулахаар жилд дунджаар 24 асуудлыг боловсруулсан байна.

ЭМГ нь 2018 онд 4 чиглэлээр 59 асуудлаар 83, 2019 онд 8 чиглэлээр 102 асуудлаар 87.3, 2020 онд 8 чиглэлээр 120 асуудлаар 93 хувиар тус бүр үнэлснээс үзэхэд хэрэгжилтэд ахиц гарснаар дүгнэгдсэн нь төрөөс эмийн талаар баримтлах бодлоготой уялдуулж эрүүл мэндийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаа нэмэгдсэн үзүүлэлтэйгээр илэрхийлэгдэж байна.

А.3.2. Эмийн сангуудын үйл ажиллагааг тогтворжуулах зорилгын хүрээнд 1995 онд ЭМЯ, НҮБ-ийн хүүхдийн сан хамтарсан “Эрүүл мэнд хамт олон төсөл”-өөр нэг суманд дунджаар 2.5-5.0 сая төгрөгийн санхүүжилтийн тусламж үзүүлснээс хойш төрөөс дэмжлэг туслалцаа үзүүлээгүй гэсэн тайлбарыг өгч байгаа нь төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт алдагдахад хүрч байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эм хангамж, эмийн сангуудтай хамтарч ажиллаж байгаа ЭМГ, ЭМДХ гэсэн 2 газар нь эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ, заавар зөвлөмж сургалт, сурталчилгааг явуулж ажиллажээ.

Үүнд: ЭМГ нь эмийн сангуудаас стандартын дагуу анхан шатны мэдээ тайланг хугацаанд нь авч, жилдээ 1-2 удаа хяналт шалгалтыг явуулж, лиценз сунгах хүсэлтийг ЭМ-ийн хөгжлийн төвд хүргүүлэн ажиллах тал дээр хамтарч ажилласан байна.

ЭМДХ нь сар бүр олгогдсон санхүүжилтэд хяналт хийж Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/142 тоот тушаалын хавсралтаар баталсан “Даатгалын гэрээ дүгнэх үнэлгээний хуудас”-аар жил бүр гэрээг дүгнэж үнэлгээ өгч ажилласан байна.

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хүрээнд эмийн сангуудын үйл ажиллагаа, хүний нөөц, чадавх, тогтвортой үйл ажиллагаа явуулах тал дээр сүүлийн 3 жилийн байдлаар аймаг орон нутгаас болон төрөөс дэмжлэг туслалцаа үзүүлээгүй нь Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын 9.1.3.¹² гэсэн заалтын хэрэгжилт алдагдахад хүрч байна.

Гүйцэтгэлийн аудитын түүвэрлэлтэд хамрагдсан эмийн сангуудын эм найруулагч, эм зүйч нарын саналыг сонсоход хувийн хэвшлийн үйл ажиллагаа явуулдаг болохоор төрөөс үзүүлэх ямар нэгэн дэмжлэг туслалцаанд хамрагддаггүй, ЭМТ-үүдийн эм эмнэлгийн хэрэгслийг өөрийн байранд хадгалж хамгаалдаг ч нийгмийн баталгаа байхгүй, хэдэн цагт ч хамаагүй дуудаж эм тариагаа авдаг, иймд төрөөс үзүүлж байгаа дэмжлэг туслалцаанд хамруулах бодлого хэрэгжүүлж ямар нэгэн шалгуур үзүүлэлтээр тэтгэмж туслалцаанд хамруулдаг болох саналыг дэвшүүлж байсан.

Цаашид аймаг орон нутаг эмийн сангуудын үйл ажиллагааг тогтворжуулах, хүний нөөцийг нь чадавхжуулах, үйл ажиллагааг нь дэмжих тал дээр хамтран ажиллах бодлого боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.

А.3.3. Эмийн зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллажээ.

Аймгийн НБХ, ЭМГ-ууд нь үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд Эрүүл мэндийн салбарын, бодлого, чиглэл, зорилго, зорилтын хүрээнд хамрагдах бүх асуудлыг тусган хэрэгжилтийг ханган ажилласан байна.

¹² төрөөс эмийн зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллагын тогтвортой үйл ажиллагаа, санхүүгийн болон мэргэшсэн хүний нөөцийг бэхжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааны уялдааг сайжруулахад бүх талаар дэмжлэг үзүүлэх

Эмнэлэг, ЭМТ болон эмийн сангуудын тогтвортой үйл ажиллагаа, эмийн зохистой хэрэглээ, өвчтөний эрт илрүүлэг, хүний нөөцийн тогтворжуулах сургалт уралдаантай холбоотой үйл ажиллагаануудыг хувийн хэвшлийн ТББ-уудтай хамтарч зохион байгуулан ажилласнаар өвчлөлийн тоо буурсан үзүүлэлтэй байна.

Тухайлбал: “Элэг бүтэн монгол хөтөлбөр”-өөр 2016 онд 44 тохиолдол шинээр бүртгэгдэж байсан бол 2017 онд 77, 2018 онд 44, 2019 онд 25 тохиолдол шинээр бүртгэгдсэн нь илрүүлгийн тоо буурсан, мөн донорын эгнээг өргөжүүлж цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх ажил хийгдсэнээр цусны нөөц нэмэгдсэн үзүүлэлттэй тус тус гарсан нь хамтын ажиллагаа үр дүнтэй гэдгийг илэрхийлж байна.

А.3.4 Эм зүйн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа боловч сүүлийн жилүүдэд сургалт явагдаагүй нь төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэгдэж байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ЭМТ-үүдийн, эмийн сангуудын эмийн санч, эм баригч нар нь тухайн жилдээ 6 кредит цуглуулах тасралтгүй боловсролын сургалтуудад хамрагдсанаар лицензээ сунган ажиллажээ.

2018-2019 онуудад хийгдсэн сургалтуудын төрлийг дурдвал: 2018 онд “Үрэвслийн эсрэг дааврын бус бэлдмэлийн клиникийн зохистой хэрэглээ” сургалт-1 кр, “Амьсгалын замын цочмог халдварт өвчнөөс сэргийлэх ба эмчлэх вирусийн халдварын үүсэх уршиг” 1 кр, “Бага насны хүүхдийн амьсгалын цочмог халдварын үеийн тусламж үйлчилгээ” 1 кр, “Эмийн мэргэжилтний ёс зүй хариуцлага” 2 кр, “Хүүхдийн цочмог хордлогын үеийн яаралтай тусламж үйлчилгээ” 1 кр, 2019 онд “Эмийн түүхий эдийн чанар аюулгүй байдал” 2 кр, “Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр хөдөлмөрчдөд сургалт мэдээллийг хийх арга замууд” -2кр, “Ханиад томуугийн үед халдвараас сэргийлэх, дархлаа дэмжих, эрүүлжүүлэх цогц менежмент” 2 кр нийт тус бүр жилдээ цуглуулах 6 кредит сургалтад хамрагдаж, сургалтуудыг УБ хотод “Монголын эм зүйн байгууллагын нэгдсэн эм холбоо” ТББ, эм ханган нийлүүлэлт, аймгийн ЭМГ-т зохион байгуулж явагддаг гэх боловч 2020 онд ковид цар тахалтай холбогдуулан нэг ч сургалт хийгдээгүй хэр нь 6 кредит оноог шууд өгчээ.

Энэ нь Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын 6.3.1.¹³, 6.3.2.¹⁴, 6.3.3.¹⁵, 6.4.¹⁶ гэсэн заалтуудын хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэгдэж байна.

Б. Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжүүлснээр хүн амын өвчлөл буурсан ч эмийн зохистой хэрэглээ бүрэн төлөвшөөгүй байна.

Б.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэх ажил хийгдээгүй байна.

Б.1.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүйгээс аймгийн хэмжээнд төлөвлөгөө боловсруулж батлаагүй.

УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг хэрхэн хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүйгээс аймгийн хэмжээнд төлөвлөгөө боловсруулж батлаагүй байна.

Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн ИТХ-ын 2017 оны 87 дугаар тогтоолоор “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг орон

¹³ эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрт эмийн талаар баримтлах бодлого, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлзүйн удирдамж, эмийн зохистой хэрэглээ, эмийн гаж нөлөө, хордлогоос сэргийлэх, хэрэглэгчдэд өгөх зөвлөмжийн асуудлыг тусгах

¹⁴ эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрт эмийн талаар баримтлах бодлого, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлзүйн удирдамж, эмийн зохистой хэрэглээ, эмийн гаж нөлөө, хордлогоос сэргийлэх, хэрэглэгчдэд өгөх зөвлөмжийн асуудлыг тусгах

¹⁵ эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрт эмийн талаар баримтлах бодлого, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлзүйн удирдамж, эмийн зохистой хэрэглээ, эмийн гаж нөлөө, хордлогоос сэргийлэх, хэрэглэгчдэд өгөх зөвлөмжийн асуудлыг тусгах

¹⁶ Эмийн мэдээлэл ба эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг дараах чиглэлээр зохион байгуулна.

нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тусган баталжээ.

Хөтөлбөрийг боловсруулахдаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээр, аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимаар хамтран ажиллагч төр болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдөөр, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар тус тус нэг, ДЭМБ-ын санал, зөвлөмж тусгах уулзалтаар 2 удаа хэлэлцүүлэн батлуулж мөрдөн ажиллаж байна.

Уг хөтөлбөрийг 2017-2026 онд баримтлахаар баталсан бөгөөд эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр 2.4.6-д дөрвөн арга хэмжээ буюу

1. Эмийн чанар, аюулгүй байдлын баталгааг хангах
2. Эрүүл мэндийн байгууллагуудын эмийн хангамж, хүртээмжийг сайжруулж, хүн амын дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх
3. Эмийн эргэлтийн санг менежментийн хувьчлалаар хувьчлах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран шат дараатай зохион байгуулах
4. Аймгийн төвд 24 цагийн үйл ажиллагаатай эмийн санг тогтмол ажиллуулахаар тусгасан байна.

Б.1.2. Эрх зүйн орчин бүрдсэн ч хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит үнэлээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хоёр үе шаттайгаар нэгдүгээр үе шат 2017-2021 он, хоёрдугаар үе шат 2022-2026 онд хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ үнэлгээний дагуу дотоод үнэлгээг хоёр жил тутам, хөндлөнгийн үнэлгээг дөрвөн жил тутам хийж гүйцэтгэхээр тусгасан ч байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит үнэлээгүй байна.

“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр хэрэгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн 2017-2019 оны хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын 2020 оны 06 дугаар хуралдаанд танилцуулж ИТХ-ын тэмдэглэлд амжилттай хэрэгжсэн талаар тусгасан байна.

Танилцуулгын материалаас 2.4.6-д заагдсан арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнгийн талаар товч дурдвал: */Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/*

- 2 эм хангамж, 34 эмийн сан эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй ханган, эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн ажиллаж байна.
- Аймгийн хэмжээнд яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж 96 хувь, зайлшгүй шаардлагатай эмийн хангамж 86.2 хувьтай байна.
- Хүн амын дунд “Эмийн зохистой хэрэглээ”-г төлөвшүүлэх 3779 удаагийн сургалтыг зохион байгуулж 17491 хүнийг хамруулсан, сүүлийн 3 жилийн байдлаар эмийн гаж нөлөөний 25 тохиолдол бүртгэгдэж, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлээ.
- Менежментийн хувьчлалаар 5 “Эмийн эргэлтийн сан”-г хувьчилсан
- Булган суманд 24 цагийн үйлчилгээ үзүүлэх эмийн сантай болсон.

ЭМГ-ийн даргын 2018 оны А/13 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг болон журмыг шинэчилсэн, мөн ЭМГ-ын даргын 2017 оны А/17 дугаар тушаалаар “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн баталсан ч

журмын 1.1¹⁷, 3.1.4¹⁸, 3.1.5¹⁹, 3.2.1²⁰, 4.2²¹, 4.5²², 5.2.3²³, 6.1.1²⁴, 6.1.2²⁵ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Б.1.3 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бодлогын хэрэгжилтэд эцсийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцсон уу.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу ЭМЯ-ны асуудал тул орон нутагт хамааралгүй асуудал болно.

Б.2 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт сурталчилгаа, заавар зөвлөмжийг өгч ажилласан байна.

Б.2.1 Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016 стандартыг шинэчлэн боловсруулах шаардлага үүссэн байна.

Аймгийн хэмжээнд нийт 37 эмийн сангаас хөнгөлөлтэй эмээр үйлчилдэг 25 эмийн сан, хөнгөлөлтэй эмийн сангаар үйлчилдэггүй 12 эмийн сан үйл ажиллагааг явуулж байна.

Гүйцэтгэлийн аудитаар Орхон, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг, Булган гэсэн 5 сумын 7 эмийн сангийн үйл ажиллагаа болон анхан шатны бүртгэл маягт, сургалт хийсэн гарын авлага, тайлан, материалтай танилцахад сум орон нутгийн иргэдэд эмийн зохистой хэрэглээ, антибиотикийн хэрэглээ, томуу, томуу тост өвчин, ЭМ-ын даатгалын тухай, хөнгөлөлт, ЭМД-д хамрагдсаны ач холбогдол, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, жор бичилт зэргээр сургалт хийж гарын авлага тараах материал бэлтгэн ажилласан байна.

Мөн түүвэрлэлтэд хамрагдсан эмийн сангуудын эмийн хөнгөлөлтийн иргэдийн жагсаалт, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, жороор олгож буй эмийн анхан шатны баримтуудыг түүвэрлэн үзэхэд эмийн санд тавигдах шаардлага MNS 5260:2015 стандартад тусгагдсаны дагуу анхан шатны баримтын бүртгэлийг хадгалж байгаа ч зарим баримтыг устгасан, анхан шатны баримт дутуу, ашиглаж байгаа программ дээрээс тулгалт хийхэд өмнөх оны мэдээлэл устсан гэх шалтгаанаар харах боломжгүй байлаа.

Өнөөгийн байдлаар жороор олгож байгаа эмийн жорын маягтуудаас жор бичилтийн маягыг сүүлийн сараар үзэхэд цахимд шилжсэн ч зарим сумын ЭМТ-ийн эмч дөрвөлжин цаасны булан дээр 6 оронтой кодыг бичиж, зарим сумын ЭМТ-ийн эмч нь жорын маягтад 6 орон тоог бар кодтой нь хэвлэж өгч явуулснаар эмийн санч тухайн жороор олгох эмийг олгож байгаа нь ЭМТ-үүд нь нэг чиглэлтэй уялдаа холбоогүй ажиллаж байгааг илэрхийлж байна.

Эмийн жорын маягт, жор бичилт MNS5376:2016 стандартыг баримталж ажиллахгүй байгаа нь уг стандарт нь өнөөгийн нөхцөлд хэрэглэгдэхгүй шинэчлэгдэх шаардлагатай болсныг мөн илэрхийлж байна.

Иймд эмийн сангуудын ашиглаж байгаа программ хангамжийг сайжруулах, цаашид бүх мэдээллийг цахим архив үүсгэн хадгалж байхаар зохицуулалт хийж шинэчлэгдэн гарсан хууль, журам, тогтоолоор сургалт хийж ажиллах шаардлагатай байна.

¹⁷Бодлогын баримт бичиг, хуль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Нутгийн өөрөө удирдах ёсны болон Нутгийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэр, аймгийн хэмжээнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа, эрүүл мэндийн салбарын харилцааг зохицуулж буй эрх зүйн актын хэрэгжилтийн үр дүнг үнэлж дүгнэхтэй холбогдсон зохицуулна.

¹⁸Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан дүгнэлт нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх,

¹⁹Хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх,

²⁰Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрт дараах баримт бичиг хамаарна,

²¹Аймгийн Эрүүл мэндийн газар нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна,

²²Тухайн Эрүүл мэндийн байгууллагын холбогдох мэргэжилтнүүд нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд болон шаардлагатай тохиолдолд тэр даруй үнэн зөв бодитой гаргаж өгөх үүрэгтэй,

²³Хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах,

²⁴Эрүүл мэндийн газар жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батална. Төлөвлөгөөнд зорилго, зорилт, хамрагдах байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хамтран оролцох байгууллага зэргийг тусгана,

²⁵Эрүүл мэндийн газар нь үнэлгээний зорилгоос хамааруулан үр дүнд суурилсан явцын болон эцсийн үнэлгээ хийх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд ямар төрлийн үнэлгээг хийх талаар нарийвчлан тусгана

Б.2.2 Эм зүйн ба эмнэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлэх, нөхцөл бүрдсэн ч иргэдэд эмийн зохистой хэрэглэх дадал төлөвшсөн эсэхийг тодорхойлж, мэдээллээр бүрэн хангагдсан эсэхэд хийсэн судалгаа, үнэлэлт өгсөн ажил хангалтгүй байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг аймаг орон нутгийнхаа ард иргэд, хэвтэн эмчлүүлэгчдэд эмийн зохистой хэрэглээ, тусламж үйлчилгээг ЭМГ, эмийн сангуудын эмийн санч, нэгдсэн эмнэлгийн эм зохицуулах хороод нь эм, эмнэлгийн тухай хуульд тусгагдсаны дагуу эмийн сургалт, сурталчилгаа, эмийн зохистой хэрэглээ, хангалт, антибиотикийн зохистой хэрэглээ, мэдээ, мэдээллийг түгээж, төлөвшүүлэх ажлыг гүйцэтгэж байна.

Гэвч иргэдэд эмийн зохистой хэрэглэх дадал төлөвшсөн эсэхийг тодорхойлж, мэдээллээр бүрэн хангагдсан эсэхэд хийсэн судалгаа, үнэлэлт өгсөн ажил хангалтгүй байна.

Б.2.3 Мэргэжлийн бэлтгэх болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт эмийн талаар баримтлах бодлогын асуудлыг мэргэжлийн холбоо, эмийн зөвлөлийн саналыг харгалзан боловсруулж, хэрэгжүүлсэн үү.

Орон нутагт мэргэжилтэн бэлтгэх сургалт, сургууль байхгүй тул хамааралгүй болно.

Б.2.4 Эмийн зохистой хэрэглээний талаар хийсэн сургалт, сурталчилгааны давтамж тодорхой бус, үр дүнг тооцож, үнэлээгүй байна.

Иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаар 2018-2020 онд "Эм зүйч, эм найруулагч, үйлчлүүлэгчийн ёс зүй, харилцаа хандлага", "Эмийн чанар, аюулгүй байдал", "Антибиотикийн зохистой хэрэглээ", "Антибиотикийн даслаас урьдчилан сэргийлэх", "Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх" сургалтуудыг танхимаар болон цахимаар зохион байгуулж давхардсан тоогоор жилд дунджаар 264 иргэд, 152 эм хангамжийн байгууллагын эмийн мэргэжилтэн хамрагдсан ч сургалт явуулсан давтамж тодорхойгүй, үнэлээгүй, үр дүнг тооцоогүй байна.

Эмийн зохистой хэрэглээ, чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний 2018-2020 оны сургалт, сурталчилгаа

/Хүснэгт 2/

Агуулга	2018 он		2019 он		2020 он		Дундаж	
	Эм хангамжийн байгууллага	Иргэд	Эм хангамжийн байгууллага	Иргэд	Эм хангамжийн байгууллага	Иргэд	Эм хангамжийн байгууллага	Иргэд
"Эм зүйч, эм найруулагч, үйлчлүүлэгчийн ёс зүй, харилцаа хандлага", "Эмийн чанар, аюулгүй байдал" сэдэвт сургалт	120		120				240	
"Антибиотикийн зохистой хэрэглээ", "Антибиотикийн даслаас урьдчилан сэргийлэх" цахим сургалт	32		32				64	
"Эмийн зохистой хэрэглээ"-г төлөвшүүлэх		60		60		672		264
Нийт	152	60	152	60	0	672	304	264

Дундаж	76	60	76	60	0	672	152	264
--------	----	----	----	----	---	-----	-----	-----

/Эх сурвалж: мэргэжилтний 2018-2020 оны жилийн эцсийн тайлангуудаас түүвэрлэв/

Дээр дурдсан 2017-2019 оны гүйцэтгэлийн танилцуулгад нийт сургалтад хамрагдсан иргэд, олон нийтийн дүн зөрүүтэй, байгууллагын албан хаагчдын хоорондын уялдаагүйгээс үнэн зөв мэдээллээр хангаагүй байх эрсдэлтэй байна.

Аймгийн төвд үйл ажиллагаа эрхэлж байгаа эмийн сантай түүвэрлэн танилцахад эмийн талаар авч хэрэгжүүлж буй сургалтыг дотооддоо болон гадагш чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулдаг, бүртгэл хөтөлж баримтжуулдаг, зарим эмийн санд бүртгэл байхгүй бөгөөд ЭМГ-аас ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг хэрхэн тооцож хүргүүлдэг талаар тодруулахад зарим тохиолдолд цахимаар хариу хүргүүлдэг тайлбар өглөө.

ЭМГ-аас эм хангамжийн байгууллагын дарга, эрхлэгч нарт 4 удаагийн албан тоотоор иргэд, олон нийтэд эмийн зохистой хэрэглээний талаар сургалт явуулах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Эм ханган нийлүүлэх байгууллага нь авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг цахимаар ирүүлдэг гэсэн боловч уг баримт материалтай танилцаагүй тул харьцуулалт хийх, дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

Аудитаар 1 албан шаардлага, 10 зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Монгол Улсад бүртгэлтэй эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж байгаа ч төрийн болон ТББ-уудтай хамтран ажиллах гэрээг бүрэн байгуулж ажиллаагүй байна.
- ЭМТ-ийн эм эмнэлгийн хэрэгслийн хамгаалалт, хадгалалт, хүний нөөц дутмаг байна.
- Шинээр үүсгэн байгуулагдаж байгаа эмийн сангийн байршил хоорондын зай ойрхон нэг дор төвлөрсөн байна.
- Эрүүл мэндийн даатгалын сангаас 2018-2020 онуудад нийт 14093.6 сая төгрөгийн санхүүжилт авсан нь төрөөс дэмжлэг үзүүлсэн гэж үзжээ.
- Сумдын ЭМТ болон өрхийн эмнэлгүүд эрүүл мэндийн багц үйлчилгээг жигд хүртээмжтэй явуулаагүй.
- Эмийн зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа бодлого, чиглэл харилцан уялдаатай, нэгдсэн зохицуулалтайгаар боловсруулагдсан байна.
- Эмийн сангуудын үйл ажиллагааг тогтворжуулах зорилгын хүрээнд 1995 онд ЭМЯ, НҮБ-ийн хүүхдийн сан хамтарсан “Эрүүл мэнд хамт олон төсөл”-өөр нэг суманд дунджаар 2.5-5.0 сая төгрөгийн санхүүжилтийн тусламж үзүүлснээс хойш төрөөс дэмжлэг тусалцаа үзүүлээгүй гэсэн тайлбарыг өгч байгаа нь төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт алдагдахад хүрч байна.
- Сүүлийн жилүүдэд сургалт явагдаагүй нь төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэгдэж байна.
- Жороор олгож байгаа эмийг сүүлийн сараар үзэхэд зарим сумын ЭМТ-ийн эмч дөрвөлжин цаасны булан дээр 6 оронтой кодыг бичиж, зарим сумын ЭМТ-ийн эмч нь жорын маягтад 6 орон тоог бар кодтой нь хэвлэж өгч байгаа нь ЭМТ-үүд нь нэг чиглэлтэй уялдаа холбоогүй ажиллаж байгааг илэрхийлж байна.
- Жороор олгож байгаа эмийн жагсаалтыг кодоор нь шалгахад өмнөх оны эмийн хөнгөлөлтөд хамрагдсан иргэдийн мэдээлэл утсан, цахим архив үүсгэж ажиллаагүй.

- Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016 стандартыг шинэчлэн боловсруулах шаардлага үүссэн байна.
- Эрх зүйн орчин бүрдээгүйгээс аймгийн хэмжээнд төлөвлөгөө боловсруулж батлаагүй.
- ЗГ-ын 2017 оны 24 дүгээр тогтоолын дагуу аймгийн ИТХ-ын 2017 оны 87 дугаар тогтоолоор дэд хөтөлбөр батлуулсан ч хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит үнэлээгүй байна.
- “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн 2017-2019 оны хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын 2020 оны 06 дугаар хуралдаанд танилцуулсан,
- Эмийн зохистой хэрэглээний талаар хийсэн сургалт, сурталчилгааны давтамж тодорхой бус, үр дүнг тооцож, үнэлээгүй байгаа нь төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө бага гэж дүгнэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Үүнд:

Нэг: Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ, Нийгмийн бодлогын хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч Д.Оюунбилэг, Эрүүл мэнд бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Нямдэлгэр нарт:

- Эмийн санд тавигдах шаардлага, стандартын дагуу эмийн сан хоорондын зай, байршлыг оновчтой тогтоож өгөх тал дээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Эм био бэлдмэлийн хяналтын улсын байцаагч авч ажиллуулах
- Аймаг, сумдын эмийн сангуудын үйл ажиллагааг тогтворжуулах, хүний нөөцийг нь чадавхжуулах, үйл ажиллагааг нь дэмжих тал дээр хамтран ажиллах

Хоёр: ЭМГ-ын дарга С.Нарантуяа, эмийн мэргэжилтэн Ө.Баасансүрэн нарт

- ЭМТ-ийн эм баригч, эмийн санч нарт өгөх сургалтыг үр дэйдүнтэй, тасралтгүйгээр хэрэгжүүлж ажиллах.
- ЭМГ-ын даргын 2017 оны А/17 дугаар тушаалаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д заасны дагуу үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган үнэлэх,
- Сумдын ЭМТ, өрхийн эмнэлгүүдийн 4 багц үйлчилгээг жигд хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх тал дээр арга хэмжээ авч ажиллах.
- Эмийн зохистой хэрэглээний талаар иргэд, олон нийт, эм хангамжийн байгууллагын гүйцэтгэлийг үнэлэх, үр дүнг тооцох,

Гурав: ЭМДХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Чулуунчимэгт:

- Эмийн сангуудын ашиглаж байгаа программ хангамжийг сайжруулах, цаашид бүх мэдээллийг цахим архив үүсгэн хадгалж байхаар зохицуулалт хийж ажиллах.
- Жор олголтын маягтыг нэг чиглэлд оруулж уялдаа холбоотой ажиллах.
- Шинээр гарсан хууль, дүрэм, журам, тогтоол, стандартын сургалтыг цаг тухайд нь явуулж ажиллах.

ҮАГ-т хүргүүлэх санал:

- Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар баталсан Эргэлтийн эмийн сангийн ажиллах журмыг мөрдөж ажилладаг тул Эмийн сангийн үйл ажиллагааны журмыг шинэчилж боловсруулах
- Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016 стандартыг шинэчлэн боловсруулах шаардлага үүссэн байна.

- Эмийн сангуудын эм зүйн, эм найруулагч нарт төрөөс үзүүлэх дэмжлэг туслалцаа байхгүй тул ямар нэгэн шалгуур үзүүлэлтээр дэмжлэг туслалцаанд хамрагдуулдаг болгох зэрэг асуудлуудыг холбогдох яам байгууллагуудад хүргүүлэх

МЭДЭГДЭЛ:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж хэрэгжилт, үр дүнг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Д.АНХБАЯР
МЕНЕЖЕР	Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР	П.МӨНХТУЯА
АУДИТОР	А.СУВДАА
АУДИТОР	Э.ОДБАЯСАХ

Хавсралт 3					
Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн мөнгө					
Аудитын нэр: "Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө" гүйцэтгэлийн аудит					
Аудитын нэв: БУА-2021/03-ШТА/ГА					
Байгууллагын нэр: Бүтээн аймг дэх Төрийн аудитын газар					
No	Аудитын зорилт, чиглэл	Алдаа, зөрчлийн төм утга	Мөнгөн дүн (хувиар төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагчид байгууллагын тэмдэг, хайрбар
А	1	Эмийн сангуудын ашиглах байгаа програмын хангамжийг сайжруулах, цаашид бүх мэдээллийг цахим аргаар үүсгэн хадгалах байгаар зохицуулалт өмнө хангах	0	Зөвлөмж өгөх	Б
1	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөний аудит нийц, дүгнэлт зөвлөмж гаргах УИХ-ын болон холбоодой байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлжээ. Аудитын зорилго чиглэлээ "Хүн амыг эмчлэхэд зориулсан өсүү, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгсэлээр хангах, түгээм тусалцоо бүрдсэн	Жир олгогчийн мөнгөтэй нэг чиглэлд оруулж үндсэн холбоодой ашиглах	0	Зөвлөмж өгөх	
2	"Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр хүн амын амьсгалт буурч, эмийн эрхлэлийн хэрэгсэлээр төлөхсөн эхэн	Шинээр гарсан хууль, дүрэм, журмыг тогтоол, стандартын сурталыг цаг тухайд нь оруулж ашиглах	0	Зөвлөмж өгөх	
3	Нийт дүн				
Бэлтгэгч: Аудитор А.Сүхбаатар					
Амхан шалгагч хянасан: А.Сүхбаатар					
Хойр дахь шалгагч хянасан: Д.Амгалан					
Дарга, тэргүүлэгч аудитор: Д.Амгалан					
Огноо: 2021.11.03					
ЭМДХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэх					
Б.Чулуунчимэг					

Хэвсрэлт 3		Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн мэлт		Хэвсрэлт 3	
Аудитын нэр: "Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө" гүйцэтгэлийн зурд		Аудитын код: БУА-2021/03-ШТА-ГА		Аудитын код: БУА-2021/03-ШТА-ГА	
Байгууллагын нэр: Бугдан аймаг дахь Төрийн аудитын газар					
№	Аудитын зорилт, чиглэл	Алдаа, зөрчлийн төмөр	Мөнгөн дүн (миллион төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагч байгууллагын санал, тайлбар
1	ЗМТ-ийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах стандартын нөхцөлийг өөрчлөх ажлыг зохион байгуулж амжилт	ЗМТ-ийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах стандартын нөхцөлийг өөрчлөх ажлыг зохион байгуулж амжилт	0	Албан шаардлага өгөх	
2	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөнд аудит хийж дүгнэлт зохиож гарган УИХ-ын болон холбогдох байгууллага, албан тушаалтны танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт	ЗМТ-ийн эм баримт, эмийн сан нэрт өгөх сурталыг үр дүнтэй тасралтуураар хэрэгжүүлж амжилт	0	Зөвлөж өгөх	
3	"Хүн амыг эмнэлгээний өндөр мэдээлэл, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хэрэгсэл, түрээх тооллого бүрдсэн зохих	ЗМТ-ийн 2017 оны АНТ дугаар тушаалаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн"ийн байгууллагын үйл ажиллагаанд хамрагдсан, үйлдэх зохих журмыг-д заасны дагуу үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган үнэмлэх	0	Зөвлөж өгөх	
4	Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр хүн амын өвчлөлт буурч, эмийн зохистой хэрэгсэлээ төлөнхсөн зохих	Сүмдэн ЗМТ өрийн эмнэлгүүдийн 4 багц үйлчилгээнийг хүнд хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх тал арга хэмжээг авч амжилт	0	Зөвлөж өгөх	
5	Эмийн зохистой хэрэгсэлтэй талаар иргэд, олон нийт, эм хангамжийн байгууллагын гүйцэтгэлийг үнэмлэх, үр дүнг тооцох	Эмийн зохистой хэрэгсэлтэй талаар иргэд, олон нийт, эм хангамжийн байгууллагын гүйцэтгэлийг үнэмлэх, үр дүнг тооцох	0	Зөвлөж өгөх	
Нийт дүн					

Бэлтгэсэн: Аудитор А.Сүедаа

ЭМГ-ын дагла

Огноо: 2021.11.03

С Нарангуяа

Алхан шанимд хийсэн: А.Сүедаа

Холр байх шанимд хийсэн: П.Менхтүвш

Аудитын мөнгө: Д.Анхордш

Дарга, тэргүүлэх зурд: Д.Анхордш



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 11 сарын 03-ны өдөр

Дугаар 01/179

00660247 БУА-2021/03-ШТА-ГА

Булган

Зөрчил арилгах тухай

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө"-нд гүйцэтгэлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Сумдын ЭМТ нь эм, эмнэлгийн хэрэгслийг сумын эмийн сангийн нөөцийн өрөөнд, зарим ЭМТ нь өөр байгууллагын стандартын шаардлага хангахгүй өрөө, тасалгаанд хадгалж байна.

Энэ нь эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11.2.2 дахь "эмийн хадаглалт, хамгаалалтын журам зөрчих, 11.3 дахь "зориулалтын бус газар эм, эмнэлгийн хэрэгсэл хадгалах, худалдахыг хориглоно.", эмийн санд тавигдах шаардлага MNS 5260:2015 стандартын 8.1.8 дахь "эм эмнэлгийн хэрэгсэл, туслах материал, түүхий эдийг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлд хадгалах нөхцөл бүрдүүлсэн нөөцийн өрөөтэй байна" гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх зөрчлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжилтийн тайланг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЭМГ-ын дарга С.Нарантуяа, эмийн мэргэжилтэн Ө.Баасансүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Д.АНХБАЯР

Ж.ЭНХЦООДОЛ

П.МӨНХТУЯА

¹ Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 403 тоот өрөө, утас-70342716

00660247



БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг
Чин Ван Хандорж 1-103 Утас: 7034-2363
Факс: 7034-2455, E-mail: bulganemg@yahoo.com

2021.01.04 № 01/273

тантай _____-ны № _____ т

Санал хүргүүлэх тухай

БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

"Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын /БУА-2021/03/ШТА/ГА/ тайлангийн төсөлтэй танилцан дараах саналыг хүргүүлж байна.

- Сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн бүтэц үйлд ажиллагааны MNS 5081:2013 стандартад эм найруулагчийн орон тоог баталсан боловч тухайн байгууллагын төсөвт цалинг тусгадгүйгээс эмийн зохицуулалтын бодлого алдагдсан.
- "Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS260.2011 стандартаар эмийн сан хоорондын зайг 500 метр гэж заасныг "Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS260.2015 стандартаар хүчингүй болгосон тул эмийн сан хоорондын зайг өнөөдрийн байдлаар тоогтоосон эрх зүйн баримт бичиг байхгүй болно.
- "Төрөөс эмийн талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтийг орон нутагт хэрэгжүүлэх талаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Байгууллагын болон хувь хүний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд холбогдох заалтуудыг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

ДАРГА  С.НАРАНТУЯА



D:\disk\Аулсан бичиг\тоот 2021\А4